БАГЦ-2

1. Багцын ойролцоо төсөвт өртөг: Улсын төсөв 600.000.000 төгрөг
2. Төсөл арга хэмжээний нэр: "Шинэ хөдөө төсөл"-ийн хүрээнд "Сэлэнгэ" үүлдрийн 24 сартай буюу 2 настай гунжин үнээ
3. Тоо, толгой: 145 толгой
4. Байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат, Сант, Цагааннуур сум, Булган аймгийн Сэлэнгэ сумаас бэлтгэнэ.

№	Үзүүлэлт	Тавигдах шаардлага	Нийлүүлэгчийн тодорхойлолт
1	Ашиг шимийн чиглэл	Махны	
2	Үүлдэр, үүлдрийн код	"Сэлэнгэ" үүлдэр	
3	Тоо толгой	145 толгой	
4	Үүлдрийн хэв шинжийг хадгалсан зүс, галбир, бие цогцос, стандарт	Баталгаажсан Сэлэнгэ үүлдрийн үнээний үзүүлэлт, шаардлагыг хангасан, галбир, бие цогцосын ямар нэгэн согог байхгүй, дэлэн, хөхний хөгжил сайн, цээж бөгс тэнцүү байна. Үндсэн зүс нь их бие хүрэн улаан, улаан, ягаан, дух, омруу, хээлүүр, шилбэ, сүүлний үзүүр цагаан, хамрын толио цайвар бор байх	
5	Зан, ааш	Элдэв гаж араншингүй, номхон дөлгөөн байх	
6	Амьдын жин, нас /кг/	Нийлүүлэх үнээ тус бүр нь 280-кг доошгүй амьдын жинтэй, 2 настай /24 сартай/ байх.	
7	Үржлийн үзүүлэлтүүд:	Мал бүр хувийн дугаар бүхий ээмэгтэй байх, эцэг, эхийн гарваль, ашиг шим тодорхой, эцэг нь үр төлийн чанараар шалгагдсан байх бөгөөд эдгээр нь баталгаажсан гэрчилгээтэй байх. Үржлийн тарга хүчтэй, биеийн хэвийн хөгжилтэй, бие галбирын согоггүй байх.	
8	Эрүүл мэнд	Малын халдварт бруцеллёз, сүрьеэ, ижбалмад, лейкоз болон гоц халдварт хөх хэлтэх, үхрийн тархи сархиатах, боом, дуут хавдар, мялзан, шүлхий (0, А, Ази-1) өвчний голомтгүй бүс нутгаас бэлтгэгдсэн, малын эрүүл мэндийн улсын кодекст заагдсан шинжилгээгээр эрүүл болох нь батлагдсан байх	
9	Баталгаажуулалт	Үржлийн малын арчилгаа, маллагааны технологийн заавар, зөвлөмжийг Монгол хэл дээр гаргасан байх, Үхэр тус бүрийн фото зураг, үржлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн байх.	
10	Зөвшөөрөл	Шаардахгүй	
11	Малыг хүлээн авах эцсийн цэг, байршил:	Үхрийг зориулалтын тээврийн хэрэгслээр Архангай аймагт хүлээлгэн өгөх.	
11	Нийлүүлэх 2 настай гунжин үнээний нэгж үнэ (мян.төг)		

1. Төсөл арга хэмжээний нэр: "Шинэ хөдөө төсөл"-ийн хүрээнд "Сэлэнгэ" үүлдрийн 36-48 сартай буюу 3-4 настай тугалтай үнээ
2. Тоо, толгой: 60 толгой үнээ, 60 толгой тугал
3. Байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат, Сант, Цагааннуур, сум, Булган аймгийн Сэлэнгэ сумаас бэлтгэнэ.

1. "Сэлэнгэ" үүлдрийн 36-48 сартай буюу 3-4 настай тугалтай үнээнд тавигдах шаардлага			
№	**Үзүүлэлт**	**Тавигдах шаардлага**	**Нийлүүлэгчийн тодорхойлолт**
1.1	Ашиг шимийн чиглэл	Махны	
1.2	Үүлдэр, үүлдрийн код	"Сэлэнгэ" үүлдэр	
1.3	Тоо толгой	60 үнээ	
1.4	Үүлдрийн хэв шинжийг хадгалсан зүс, галбир, бие цогцос, стандарт	Баталгаажсан Сэлэнгэ үүлдрийн үнээний үзүүлэлт, шаардлагыг хангасан, галбир, бие цогцосын ямар нэгэн согог байхгүй, дэлэн, хөхний хөгжил сайн, цээж бөгс тэнцүү байна. Үндсэн зүс нь их бие хүрэн улаан, улаан, ягаан, дух, омруу, хэлүүр, шилбэ, сүүлний үзүүр цагаан, хамрын толио цайвар бор байх	
1.5	Зан, ааш	Элдэв гаж аранжингүй, номхон дөлгөөн байх	
1.6	Амьдын жин, нас /кг/	Нийлүүлэх үнээ тус бүр нь 320-кг доошгүй амьдын жинтэй, 36-48 сартай буюу 3-4 настай тугалтай үнээ байх	
1.7	Үржлийн үзүүлэлтүүд:	Мал бүр хувийн дугаар бүхий ээмэгтэй байх, эцэг, эхийн гарваль, ашиг шим тодорхой, эцэг нь үр төлийн чанараар шалгагдсан байх бөгөөд эдгээр нь баталгаажсан гэрчилгээтэй байх Үржлийн тарга хүчтэй, биеийн хэвийн хөгжилтэй, бие галбирын согоггүй байх	
1.8	Эрүүл мэнд	Малын халдварт бруцеллёз, сүрьеэ, ижбалмад, лейкоз болон гоц халдварт хөх хэлтэх, үхрийн тархи сархиатах, боом, дуут хавдар, мялзан, шүлхий (0, А, Ази-1) өвчний голомтгүй бүс нутгаас бэлтгэгдсэн, малын эрүүл мэндийн улсын кодекст заагдсан шинжилгээгээр эрүүл болох нь батлагдсан байх	
1.9	Баталгаажуулалт	Үржлийн малын арчилгаа, маллагааны технологийн заавар, зөвлөмжийг Монгол хэл дээр гаргасан байх Үхэр тус бүрийн фото зураг, үржлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн байх	
1.10	Зөвшөөрөл	Шаардахгүй	
1.11	Малыг хүлээн авах эцсийн цэг, байршил:	Үхрийг зориулалтын тээврийн хэрэгслээр Архангай аймагт хүлээлгэн өгөх	
1.12	Нийлүүлэх 3-4 настай үнээний нэгж үнэ (мян.төг)		

2. “Сэлэнгэ” үүлдрийн 36-48 сартай буюу 3-4 настай тугалтай үнээний тугалд тавигдах шаардлага			
№	**Үзүүлэлт**	**Тавигдах шаардлага**	**Нийлүүлэгчийн тодорхойлолт**
2.1	Тоо толгой	60 толгой	
2.2	Эрүүл мэнд	Малын халдварт бруцеллёз, сүрьеэ, ижбалмад, лейкоз болон гоц халдварт хөх хэлтэх, үхрийн тархи сархиатах, боом, дуут хавдар, мялзан, шүлхий (О, А,Ази-1) өвчний голомтгүй бүс нутгаас бэлтгэгдсэн, малын эрүүл мэндийн улсын кодекст заагдсан шинжилгээгээр эрүүл болох нь батлагдсан байх	
2.3	Үүлдрийн шаардлага	Баталгаажсан Сэлэнгэ үүлдрийн үнээний тугалны ерөнхий үзүүлэлт, шаардлагыг хангасан, галбир, бие цогцосын ямар нэгэн согог байхгүй байх	
2.4	Нас	2-6 сартай	
2.5	Зүс	Үндсэн зүс нь их бие хүрэн улаан, улаан, ягаан, дух, омруу, хээлүүр, шилбэ, сүүлний үзүүр цагаан, хамрын толио цайвар бор байх:	
2.6	Бусад үзүүлэлтүүд	Тугал бүр хувийн дугаартай, эцэг, эхийн гарваль, ашиг шим тодорхой байх:	
		Тарга хүч хэвийн биеийн хөгжил сайтай, сэрэглэн цовоо, бие галбирын согоггүй байх:	
		Хүйсний харьцаа нь нийт нийлүүлэх тугалын 50%-иас доошгүй нь охин байх,	
2.7	Нийлүүлэх тугалний нэгж үнэ (мян.төг)		

1. Төсөл арга хэмжээний нэр: “Шинэ хөдөө төсөл”-ийн хүрээнд “Герефорд” үүлдрийн 12-18 сартай хээлтүүлэгч нийлүүлэх
2. Тоо, толгой: 16 толгой
4. Байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат, Сант, Цагааннуур, сум, Булган аймгийн Сэлэнгэ сумаас бэлтгэнэ.

№	**ҮЗҮҮЛЭЛТ**	**Тавигдах шаардлага**	**Нийлүүлэгчийн тодорхойлолт**
1	Ашиг шимийн чиглэл	Махны чиглэлийн ашиг шимтэй	
2	Үүлдрийн нэр, код	Герефорд, 0333	
3	Гарал үүсэл	Герефорд үүлдрийн үхэр нь Англий Баруун өмнөд Мидландс мужийн Херефордшир гаралтай махны чиглэлийн үүлдэр юм. Герефорд үүүлдрийн үхэр дэлхийн 50 гаруй оронд экспортлогдож амжилттай нутагшиж байна. Сэрүүн чийглэг Их Британи гарал үүсэлтэй энэ үхэр дэлхийн бараг бүх тивд дасан зохицож үржиж байгаа. Герефорд үүлдрийг сайжруулах үржлийн ажлыг бэлчээрийн маллагааны нөхцөлд удаан хугацааны туршид явуулснаар	

		ашиглах чадвар сайтай, тэжээл бага шаарддаг онцлог чадвартай болгожээ.	
4	Үүлдрийн хэв шинжийг хадгалсан зүс, галбир, бие цогцос, стандарт	**Герефорд үүлдрийн үхэр:** Түргэн өсөлт, чийрэг бие цогцос, тэсвэр хатуужилтай, махны өндөр ашиг шим өгдөг. Герефорд үүлдрийн үхрийн үндсэн зүс нь их бие улаан, толгой, сэрвээ, хондлой, хэзлүүр, омруу, сүүлний үзүүр, шийр цагаан байдаг. Өөр үүлдрийн үхэртэй эрлийзжүүлэхэд толгой, гэдэс, хэзлүүрийн цагааныг үр төлдөө баттай удамшуулдаг. Үүлдрийн дотор мухар хэвшлийн удам бий болсон бөгөөд байран маллагааны нөхцөлд уяа хэрэглэхгүй, ачиж тээвэрлэхэд талбайн ашиглалт сайтай, бие биенээ мөргөж гэмтээхгүй зэрэг давуу талтай, тайван дөлгөөн зан авиртай байдаг. Галбир бие цогцсын хувьд махны чиглэлийн өндөр ашиг шимт үүлдрийн шаардлагыг бүрэн хангадаг. Тугал төрөхдөө 28-34кг, 18 сартай охин шүдлэн 400-450кг, үнээ 500-550кг, бух 800-900кг, зарим шилмэл үнээ 720кг, бух 1100кг хүрдэг. Эрчимтэй өсгөн бойжуулсан эр бяруу 12 сарын настайдаа 420-440кг, дээд тал нь 518кг жин татаж нядлагын гарц нь 60 хувьд хүрдэг. Олон улсад үзүүлсэн түүний амжилт бух 152см өндөр, 1800кг, үнээ 140см өндөр, 1200кг жин дарж байжээ. Үнээ саалийн хугацаанд 3,9-4,0хувийн тослогтой, 1200-1800кг сүү өгдөг.	
5	Зан, ааш	Элдэв гаж араншингүй, номхон дөлгөөн байх	
6	Өсвөр хэзлтүүлэгч /бухан бяруу/ амьдын жин/кг/, нас	330-400 кг 12-18 сартай	
7	Гэрчилгээ	Мал бүр хувийн дугаар бүхий зэмэгтэй байх, эцэг, эхийн гарваль, ашиг шим тодорхой, эцэг нь үр төлийн чанараар шалгагдсан байх бөгөөд эдгээр нь баталгаажсан гэрчилгээтэй байх	
8	Эрүүл мэнд	Малын гоц халдварт өвчин Бруцеллёз, сүрьеэ, лейкоз, хөх хэлтэх, үхрийн тархи сархиатах, боом, дуут хавдар, мялзан, вибриоз, кампибактериоз, трихоманоз, лептосперо, шүлхий (О, А, Ази-1) өвчний голомтгүй бүс нутгаас бэлтгэгдсэнийг мэргэжлийн байгууллагаар баталгаажсан байх, малын эрүүл мэндийн улсын кодекст заагдсан өвчнүүдээс эрүүл болох нь холбогдох шинжилгээгээр батлагдсан байх	
9	Нийлүүлэх малын тоо, толгой	Герефорд өсвөр хэзлтүүлэгч /бяруун бух/ 16 толгой	

10	Баталгаажуулалт	Үржлийн малын арчилгаа, маллагааны технологийн заавар, зөвлөмжийг Монгол хэл дээр гаргасан байх, Нийлүүлэх хэлтүүлэгч бяруун бух тус бүрийн фото зураг, үржлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлсэн байх.	
11	Зөвшөөрөл	Шаардахгүй	
12	Малыг хүлээн авах эцсийн цэг, байршил:	Герефорд үүлдрийн үхрийг зориулалтын тээврийн хэрэгслэлээр Архангай аймагт хүлээлгэн өгөх	
13	нэгж үнэ (мян.төг)		

----oOo----